



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 12

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Г Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Даваасүрэнгийн Наранчимэгийн оронд Батсүхийн Буяндэлгэрийг, Наваанпэрэнлэйн Жанцангийн оронд Гомбожавын Туулхүүг, Тогоочийн Лхагваагийн оронд Цагааны Нанзаддоржийг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА

ХУУЛБАР ҮНЭН:

Тамгын газрын дэд дарга

Г.Байгалмаа

0000000096



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай-6,  
Утас: 26-30-83, Факс: 26-12-73  
E-mail: Office@president.mn

2018.05.18 № 77/443  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
захирамж хүргүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Наваанпэрэнлэйн Жанцан, Даваасүрэнгийн Наранчимэг, Тогоочийн Лхагваа нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилуулах тухай 12 дугаар захирамжийг үүгээр хүргүүлж байна.

Зохих журмын дагуу шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

Хавсралт 19 хуудастай.

ДАРГА

3.ЭНХБОЛД



0000002573

## ТАНИЛЦУУЛГА

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч/

**1.Овог, нэр:**

**Батсүхийн БУЯНДЭЛГЭР**

**2.Хэзээ, хаана төрсөн:**

1960 онд Дорнод аймагт төрсөн.

**3.Нас, хүйс:**

58 настай, эрэгтэй.

**4.Үндэс, угсаа:**

Буриад.

**5.Ам бүлийн байдал:**

Эхнэр, охины хамт амьдардаг.

**6.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:**

-1978 онд Дорнод аймгийн төвийн 10 жилийн 1 дүгээр дунд сургууль;  
-1984 онд ЗХУ-ын Эрхүү хотын Улсын Их сургууль;  
-хуульч мэргэжилтэй;

**7. Ажилласан байдал:**

-1984-1989 онд Дорнод аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны:  
-Зохион зааварлах хэлтэст референт;  
-Хуулийн хэлтэст ахлах зөвлөх-кодификаторч;  
-Хууль зүй, арбитрийн хэлтэст ахлах арбитрч;  
-Хуулийн хэлтсийн дарга;  
  
-1989-1991 онд Дорнод аймгийн Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Хорооны дарга;  
  
-1990-1992 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат;  
  
-1991-1993 онд Дорнод аймгийн Залуучуудын Холбооны тэргүүн;  
  
-1993-2008 онд “Нугын гол” ХХК-ийн захирал;  
  
-2008-2012 онд УИХ-ын Тамгын Газрын Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах хэлтэст ахлах референт;  
  
-2012-2015 онд “CGM” ХХК-ийн менежер;  
  
-2015 оноос “Дорнын тал экологи” ХХК-ийн захиралаар ажиллаж байна.



1992-1996, 2004-2008, 2012-2016 онуудад  
Дорнод аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр нийт 3  
удаа сонгогдон ажилласан.

**8. Гадаад хэл:**

Орос, англи хэлтэй.

---ooOoo---

## ТАНИЛЦУУЛГА

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч/

1.Овог, нэр:

Гомбожавын Туулхүү

2.Хэзээ, хаана төрсөн:

1961 онд Төв аймагт төрсөн.



3.Нас, хүйс:

57 настай, эрэгтэй.

4.Үндэс, угсаа:

Халх.

5.Ам бүлийн байдал:

Эхнэр, хүү, охины хамт амьдардаг.

6.Хэзээ, хаана, ямар  
сургууль төгссөн, мэргэжил,  
эрдмийн зэрэг, цол:

-1979 онд Дархан-Уул аймгийн 10 жилийн 3 дугаар дунд сургууль;  
- 1982 онд Дархан-Уул аймгийн Политехникум;  
-1990 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль;  
-хуульч мэргэжилтэй.

7. Ажилласан байдал:

-1982-1983 онд Инженер хайгуулын товчоонд техникич геологич;  
  
-1990-1998 онд Дархан хотын Давж заалдах шатны шүүхэд Ардын шүүгч, шүүгч;  
  
-1998-2001 онд Гаалийн ерөнхий газрын Хяналт шалгалт, хэрэг бүртгэлийн хэлтсийн дарга;  
  
-2001-2002 онд Шийдвэр гүйцэтгэлийн газарт Улсын ерөнхий гүйцэтгэгч;  
  
-2002-2007 онд Шийдвэр гүйцэтгэх газарт дэд дарга;  
  
-2007-2009 онд Шийдвэр гүйцэтгэх газарт Мэргэжлийн хяналт, тоо бүртгэл хариуцсан дэд дарга, Шийдвэр гүйцэтгэх газрын дарга;  
  
-2009-2014 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэргэжлийн хяналт шалгалтын тасгийн дарга;  
  
-2014-2015 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;

-2015-2016 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх  
ерөнхий газрын дэд дарга;

-2016-2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх  
ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэлийн асуудал  
эрхэлсэн дэд дарга;

-2017 оноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх  
ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Хорих ял  
эдлүүлэх албаны даргаар ажиллаж байна.

**8.Гадаад хэл:**

Орос хэлтэй.


---ooOoo---

## ТАНИЛЦУУЛГА

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч/

1.Овог, нэр:

Цагааны НАНЗАДДОРЖ



2.Хэзээ, хаана төрсөн:

1962 онд Говь-Алтай аймагт.

3.Нас, хүйс:

56 настай, эрэгтэй.

4.Үндэс, угсаа:

Халх.

5.Ам булийн байдал:

Эхнэр, 3 хүүгийн хамт амьдардаг.

6.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

-1980 онд Говь-Алтай аймгийн 10 жилийн 1 дүгээр дунд сургууль;  
-1987 онд ОХУ-ын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургууль;  
-1991 онд ЗГ-ын дэргэдэх Удирдлагын хөгжлийн институт;  
-2004-2007 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль -хуульч мэргэжилтэй.

7. Ажилласан байдал:

-1984-1990 онд Говь-Алтай аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргаанд мэргэжилтэн, ахлах мэргэжитэн;

-1991-1994 онд Говь-Алтай аймгийн Өмч хувьчлалын комисст ахлах мэргэжилтэн;

-1994-1996 онд “Ажираг” ББХК-д менежер;

-1996-2000 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газрын орлогч дарга, газрын дарга;

-2000-2004 онд “Гурван гол холдинг” ХХК-д дэд захирал;

-2004-2010 онд Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга;

-2010-2012 онд “Гурван гол холдинг” ХХК-д дэд захирал;

-2012-2013 Төрийн өмчийн хорооны дарга;

-2013-2015 онд “Гурван гол холдинг” ХХК-д дэд захирал;

-2015-2016 онд Төрийн өмчийн хорооны дарга;

-2016 оноос “BOD” ХХН Хуулийн фирмд хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

**8. Гадаад хэл:**

Орос, англи хэлтэй.

---ooOoo---